



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/14

Улаан-Уул

Коронавирусийн халдвараас урьдчилан
сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, сумын Онцгой комиссын 2022 оны 01 сарын 21-ний өдрийн 2 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд “Ковид-19”-ын халдвар авч эмчлэгдэж байгаа 103 иргэн байгаа ба цаашид тархалтыг нэмэгдүүлэхгүй байх зорилгоор коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлэг ухуулах хуудсыг нийтийн эзэмшлийн талбай хүний бөөгнөрөл үүсдэг цэгт байршуулж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (А.Сүхээ), сумын онцгой комиссын гишүүдэд даалгасугай.

2. Коронавируст халдварын хүндрэлээс сэргийлэх дархлаажуулалтын 3 дугаар тунгийн хамрагдалтыг эрчимжүүлэн багийн нутаг дэвсгэрт байнга оршин суугчдыг бүрэн хамруулах, дархлаажуулалтын 4 дүгээр тунгийн хамрагдалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээллийг цахимаар болон гарын авлагаар иргэдийг хангахыг Эрүүл мэндийн төвийн дарга (А.Сүхээ)-д, багийн иргэдэд хүргэх ажил зохион байгуулахыг багуудын удирдлагын багийн ахлагч нарт тус тус даалгасугай.

3. Коронавирусын халдварын түргэвчилсэн оношлуурын нөөц бүрдүүлэх, шаардлагатай тохиолдолд оновчтой хэрэглэх, иргэдэд эмнэлзүйн шинж тэмдэгээс хамаарч эхний шинжилгээг үнэ төлбөргүй авах, давтан шинжилгээг 15000 (Арван таван мянган) төгрөгийн төлбөртэйгээр авч, зарцуулалтын мэдээг 7 хоног тутам танилцуулж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (А.Сүхээ), нягтлан бодогч (Ч.Сүрэнлхам) нарт үүрэг болгосугай.

642101187

4. Коронавирусийн халдвараас өөрийгөө болон бусдыг хамгаалж, хувийн халдвар хамгааллын дэглэмийг сайтар сахихыг сумын нийт иргэдэд уриалсугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ

